

# ХАМТЫН ОВООНЫ ХАРУУЛ ДЭЭР

(Сурвалжлага)

Хурандаа бид хоёрын суусан машин дорнод монголын их талын тэнүүн шаргал ухаадыг хэжин давхисаар явав. Эх оронд маань өвөл ирсэн байсан ч цасгүй минжин сор шиг шаргал өвс халиурсан их тал үргэлжилнэ.

Бид явсаар Хавиргын заставын харьяа Хамтын овооны харуул дээр ирэв. Харуулын дарга дэд ахлагч цолтой хөрслөг бор залуу хурандаад тайвныг илтгэв. Заставынхан харуулын байраа шинээр барьж тохижуулжээ. Хаанаас нь ч харсан сэтгэлд дотно нүдэнд дулаан, хилчдийн маань амьдарч, сурч, албаа явуулдаг тэдний бас л нэг гэр. Байрныхаа дотор талыг их л гоёж цэвэр цэмцгэр болгосон байв. Түлээ түлшээ татаж буулгажээ

Эр цэргийн алба хаахад энэ бие тэнцэж хувь тохиолоор хилээ манах албанд хилчин болсондоо тэд баяртай. Бүгд л сурч дадаж буй албаараа хамтарч албаа хаадаг нөхдөөрөө бахархана.

Хамтын овооны харуулынхан хамтарч хөдөлмөрлөх, алба хаахын үлгэр жишээг үзүүлж байна. Эх орны хилийн энэ л хэсэг бидний хамтын хөдөлмөрийн талбар гэж харуулын дарга дэд ахлагч Амар бидэнд ярив. Тэдний алба амьдралтай танилцсаны дараа бидний халуун дотно яриа эхэлсэн юм. Давхарлаж зассан цэрэг орны толгойноос гитар зүүлттэй харагдав.

-Хэн энэ гитараар тоглодог юм бэ дээ гэвэл байлдагч Отгонболд мөнөөх гитарыг тоглож долоон хилчин "Эх орон" гэдэг дууг Цогмандал бид хоёрт сүрлэг сайхан дуулж өгөв.

Отгонболд Улаанбаатар хотоос цэрэгт татагдаж энд ирсэн гэнэ. Цэрэгт ирэхийнхээ өмнө нисэх төв буудалд ачигч хийж байжээ. Өнөөдөр хамтын овооны харуулын хилчин, Хавиргын заставын ардын авьяастан "Улаанбаатар"-аас энд дөрвүүлж байгаа аж. Лхагвасүрэнгийн Батбэх, Оюунзэндэмийн Эрхэмболор, Тогоочийн Булган-Эрдэнэ нар эх орныхоо нийслэлээс энэ хилд иржээ. Байлдагч Булган-Эрдэнэ: -Би цэрэгт ирэхээсээ өмнө гэрлэсэн. Нэг хүүхэдтэй тэр маань 4 сартай болж байна. Гэргий хүүхэд хоёртоо захидал бичсэн. Цэргийн алба тэр дотроо хилийн алба бахархам сайхан байна. Олон найз нөхөдтэй болж байна. Албаа сайн хааж эх орныхоо даалгаврыг биелүүлээд гэртээ харина. Миний төлөө санаа зовох юм байхгүй гэж итгэлтэй ярьсан юм.

Хамтын харуулд хамтран зүтгэгч байлдагч Дашдаваагийн

Гантөгс, Хашхүүгийн Батцэнгэл нь эх орны хойд хязгаар Сэлэнгэ аймгаас ирсэн аж. Бүгд л нутаг усныхан найз нөхдөө дурсах дуртай төдийгүй эх орныхоо хилийг манах болсондоо бахархаж, үнэнч шударга байж албаа хаах эрмэлзэлтэй байгаа аж.

Хурандаа бид хоёр ийнхүү хилчидтэй уулзаж ярилцаад “Эх орон” гэдэг сайхан дуугаар ая барьж өгсний нь хариуд талархал илэрхийлж амжилт хүсээд “Зөвхөн монголдоо” дууг хариу болгон аялж хамтын харуулын хүдэр чийрэг хилчидтэйгээ хамт дуулснаар бидний энэ удаагийн уулзалт өндөрлөв.

Эх орны минь хилийн эрхий дарам газар ч үнэтэй. Энэхүү газар шороо минь биднийг өөр дээрээ өлгийдөж байгаа бус уу. Хилийн минь газар шороонд хэн бүхний хайр шингэсэн. Хүнд хэрэг болдог бүхэн хилийн минь газар шороонд бий. Тэнд хүсэл тэмүүлэл, хайр сэтгэл, хүний амьдрал тэмцлийн бүх юм бий. Ганцхан насанд заяасан газар шороо-алтан хил минь. Бид таны байнгын харуул-хилчид билээ. Таны өмнө сөхрөн мөргөө!



Г.Дагважамц